

ЗУРАГ ЗҮЙ

Зураг зүй гэж газрын гадаргын дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцаа хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээргийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг тоон болон дүрслэлийн аргаар зохиож хэвлэх үйл ажиллагаа юм. (Монгол улсын Геодези, зураг зүйн тухай хуулиас)

Зураг зүйн бүтээгдэхүүнүүд:

ГАЗРЫН ЗУРАГ, АТЛАСЫН ЖАГСААЛТ		
д/д	нэр төрөл	хэвлэгдсэн он
1	Монгол Улсын Үндэсний атлас	1991
2	Эх газрын газарзүйн атлас (ЕБС-ийн 6-р анги)	2003
3	Рашааны зураг /монгол хэл/ 1:5000000	2003
4	Map of mineral waters /англи хэл/ 1:5000000	2003
5	Байгаль шинжлэлийн атлас	2005
6	Монголын түүхийн атлас (ЕБС-ийн 11 жилийн сургалтанд)	2006
7	Монгол орны нийгэм, эдийн засгийн атлас	2007
8	Дэлхийн нийгэм эдийн засаг, бүс нутгийн атлас /ЕБС-ийн ахлах ангид/	2009
9	1:30000000-ны масштабтай сургалтанд зориулсан ханын газрын зураг: • Дэлхийн улс төрийн зураг • Дэлхийн физик газар зүйн зураг • Дэлхийн байгалийн бүс бүслүүрийн зураг • Дэлхийн уур амьсгалын зураг	2006
10	1:1500000-ны масштабтай Монгол орны газрын зураг: • Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг • Монгол орны геологийн зураг • Монгол орны хөрсний зураг • Монгол орны уур амьсгалын зураг	2006
11	Атлас /дэлхийн/, (ЕБС-ийн сургалтанд зориулав)	2006
12	Газарзүйн атлас (ЕБС-ийн сургалтанд зориулав)	2011
13	Атлас Газарзүй-III (ЕБС-ийн 9-р анги)	2013


14	Атлас Газарзүй-IV (ЕБС-ийн 10-р анги)	2013
15	Улаанбаатар хотын атлас /монгол хэл/	2011
16	Ulaanbaatar city atlas /англи хэл/	2011
17	Дэлхийн улсуудын атлас	2013
18	Аялал жуулчлалын атлас /монгол хэл/	2011
19	Tourist atlas Mongolia /англи хэл/	2011
20	Монгол Улс Газарзүйн атлас /монгол хэл/	2004-2020
21	Mongolia Geographic atlas /англи хэл/	2004-2013
22	Байр зүйн 1:500, 1:1000, 1:2000, 1:5000 масштабтай зургийн таних тэмдгийн ном	2011
23	Байр зүйн 1:25000, 1:50000, 1:100000 масштабтай зургийн таних тэмдгийн ном	2011
24	Монгол орны физик газар зүйн цомог зураг /21 аймаг тус бүрээр/	2011
25	Цомог газрын зураг /сургалтын/: • БНМАУ-ын засаг захиргаа (1931-1939 он) 1:4200000 • БНМАУ-ын засаг захиргаа (1924-1929 он) 1:4200000 • Жоужань улс-Монгол нирун (330 оны үеэс 555 он) 1:7500000 • Хүннү гүрэн (MTӨ-MT 93 он) 1:7500000 • Монгол Улсын засаг захиргаа (2011 он) 1:4200000 • Түрэг улс (552-745 он) 1:7500000 • Сяньби (Сүмбэ) улс (II-IV зуун) 1:7500000 • Их Монгол улс (1206 он) 1:7500000 • Олноо өргөгдсөн МУ (1911-1912 он) 1:7500000 • Кятан (Кидан) улс (907-1126 он) 1:7500000 • Уйгар улс (745-840 он) 1:7500000	2011
26	Ханын газрын зураг /сургалтын/: • Монгол орны түүх, соёлын өвийн газрын зураг 1:2500000 • Монгол орны ус зүйн сүлжээний газрын зураг 1:2500000 • Монгол орны байгаль хамгааллын газрын зураг 1:2500000 • Монгол орны ан амьтаны тархалтын газрын зураг 1:2500000	2014

27	21 аймгийн хаягийн атлас	2018
28	Монгол Улсын засаг захиргааны зураг /брайль/	2018
29	Дэлхийн физик газар зүйн зураг /брайль/	2018
30	116-р сургуулийн план зураг /брайль/	2018
31	116-р сургууль орчмын план /брайль/	2018
32	Монгол Улсын атлас /брайль/	2019
33	Монгол газар нутгийн дэвсгэр нэрийн зурагт тайлбар толь	2019

6.1. Газрын зураг, атлас

Газрын зураг, атлас

Тус газар нь улс орныг зурагжуулах бодлогын хүрээнд зураг зүйн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарыг төрөл бүрийн масштабтай газрын зургаар хангах сэдэвчилсэн зураг, атласыг нийтийн хэрэгцээнд болон сургалтанд зориулан хангах бодлого боловсруулан хэрэгжүүлдэг юм. Нийтийн болон сургалтад зориулан дараах газрын зураг, атласуудыг зохиож, хэвлүүлжээ.



6.2. Газрын зургийн нэг маягийн суурь


Газрын зургийн нэг маягийн суурь

Газрын зургийн нэг маягийн суурь гэдэг нь байр зүйн болон сэдэвчилсэн зургуудад бүгдэд нь нийтлэг ордог улсын болон засаг захиргааны нэгжийн баталгаажсан хил, суурин газрууд, ус зүй, авто болон төмөр зам, ой, хаялбар, газар зүйн нэр зэрэг газар

зүйн элементүүдийг тухайн масштабын газрын зураг дээр дүрслэгдэх байдлаар нь зураг зүйн аргаар зураглан, стандарт болгон зохиосон газрын зураг /эталон/ юм. Газрын зураг нь аливаа юмс үзэгдлийн байршил, хэмжээ, мөн чанар, хөгжил хөдөлгөөн зэргийг зураг зүйн дүрслэлийн аргуудын тусламжтайгаар хэрэглэгчдэд хүргэх үндэс суурь болдог ба баталгаажсан газрын зургийн нэг маягийн суурийг олон нийтэд түгээснээр янз бүрийн хэлбэр хэмжээ, гажилттай газрын зураг хэрэглэхийг зогсоох боломжыг бүрдүүлж байгаа юм. Нийт 9 төрлийн масштабын газрын зургийн нэг маягийн суурь ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэст хадгалагдаж байна.

Нэр төрөл	2015 он	2017 он
Нэг маягийн суурь /масштабаар/	1:1000000, 1:6000000 1:9000000, 1:12000000	-
	-	1:500000, 1:1500000 1:2500000, 1:3000000 1:5000000

1:6'000'000 масштабын суурь



Зураг 1. 1:6000000-ны масштабтай нэг маягийн суурь